

**НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: СОНГОХ ДААЛГАВАР**

**Санамж: 1. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.  
2. Сонгох даалгавраас зөвхөн нэг хариултыг сонгоорой**

1. Нийгмийн гишүүн бүр аав, ээжийн хүү /охин/, хэн нэгний ах дүү, аль нэг баг, хамт олны төлөөлөгч, сайн дурын ажилтан гэх мэт нийгмийн өөр өөр үүргийг гүйцэтгэдэг. Энэ нь нийгмийн ямар ойлголтын жишээ вэ? **/1 оноо/**

A. Нийгмийн байр суурь	B. Нийгмийн үүрэг	C. Иргэний үүрэг
D. Үүргийн зөрчил	E. Үүргийн тогтолцоо	
2. Цэгийн оронд тохирох хариултыг олно уу? .....гэдэг нь судлаач урьдчилан бэлтгэсэн асуулгыг судалгаанд оролцогчдоор болон өөрөө асууж бөглүүлдэг аргыг хэлнэ. Энэ нь: **/1 оноо/**

A. Ажиглалтын арга	B. Түүврийн арга	C. Ярилцлагын арга
D. Асуулгын арга	E. Индукцийн арга	
3. Нийгэмшилт хүний насан туршид явагддаг хэмээх санааг анх удаа судлаач Орвиль Г.Брим дэвшүүлсэн байна. Тэгвэл түүний үзсэнээр хүүхдийн нийгэмшилтийн шинж аль нь вэ? **/1 оноо/**

A. Гадаад зан төлвийн өөрчлөлтөөр илэрхийлэгддэг.
B. Хэм хэмжээг үнэлэх чадвартай
C. Суурь үнэлэмж баримжаалалд нөлөөлдөг.
D. Туршлага арга барил эзэмшихэд чиглэгддэг.
E. Хувь хүний ажил мэргэжил нөлөөлдөг.
4. Нийгмийн тухай онолын олон хандлагууд байдаг. Дараах эрдэмтдийн аль нь зөрчилдөөний хандлагын төлөөлөгч вэ? **/1 оноо/**

A. М.Вебер	B. Ч.Куули	C. Р.Мертон	D. К.Маркс	E. Т.Парсонс
------------	------------	-------------	------------	--------------
5. Нийгэмшилтийн интеграцийн шат буюу нийгэмд эзлэх байр сууриа эрж хайх эрмэлзлэлийн үетэй холбогдох бодомжийг олно уу? **/2 оноо /**

A. Хүүхэд төрсөн цагаасаа эхлэн өсвөр нас хүртлээ нийгмийн туршлагыг шүүмжлэхгүйгээр хүлээн авч дасах үе шат
B. Бие хүний шинж чанар тогтвортой бүрэлдэж нийгэмшлийн шинж чанар тогтворждог үе
C. Тухайн хүнийг нийгэм бүлгээрээ хүнлэг байдлаар хүлээн авбал сайн сайхнаар, эсрэг тохиолдолд түрэмгий харгис, эсвэл идэвхгүй ноомой болж хувирдаг үе
D. Насанд хүрсэн хүний амьдрал, хөдөлмөрийн үйл ажиллагааны үе
E. Өөрийн эзэмшсэн нийгмийн туршлагыг хойч үедээ дамжуулан уламжлуулах үе
6. Хэдэн зуугаас хэдэн мянган хүмүүс, хэд хэдэн овгоос бүрдсэн хүмүүсийн үлэмж томоохон нийгмийн нийтлэгийн хэлбэр аль нь вэ? **/1 оноо/**

A. Үндэстэн	B. Ястан	C. Аймаг
D. Ураг төрлийн холбоо	E. Угсаатан	
7. Газар тариаланд анжисыг нэвтрүүлсэн нь тариалангийн цар хэмжээ, үр өгөөжийг ихээр нэмэгдүүлж, түүнийг дагасан суурьшил, солилцоо, зохицуулалтуудыг бий болгосон. Энэ нь нийгмийн ямар хэв маяг вэ? **/2 оноо/**

A. Аж үйлдвэржсэний дараах нийгэм	B. Ан агнуур, түүврийн нийгэм
C. Тариалан, мал аж ахуйн нийгэм	D. Аж үйлдвэржсэн нийгэм
E. Хөдөө аж ахуйн нийгэм	
8. Жижиг бүлгүүдэд хэн нэгнийг буруу зүйл хийсэн, тогтсон хэм хэмжээг зөрчсөн хэмээн нүд үзүүлэх, шүүмжлэх, шоолох зэрэг нь нийгмийн хяналтын ямар төрөлд хамаарах вэ? **/1 оноо/**

A. Албан бус хяналт	B. Албан хяналт	C. Хамт олны хяналт
D. Олон нийтийн хяналт	E. Бүлгийн хяналт	



## 9. Өрхийн ядуурлын хэмжүүрийг зөв харгалзуулна уу?

**/2 оноо/**

1	Нөөц	A	Мэдээлэл авах боломж, ашиглах чадвар, боловсролын түвшин, өөрийгөө илэрхийлэх чадвар
2	Амьжиргаа	B	Өрхийн гишүүдийн боловсрол, эрүүл мэндийн байдал, нийгмийн үйлчилгээг хүртэх боломж
3	Мэдлэг	C	Өрхийн орлого, өрх өөрийгөө санхүүжүүлэх чадвар, өрхийн хэрэглээ хөрөнгө

A. 1b 2a 3c

B. 1b 2c 3a

C. 1a 2b 3c

D. 1c 2b 3a

E. 1a 2c 3b

10. Цэгийн оронд тохирох хариултыг олно уу? ..... гэдэг нь эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж асрамж дутагдалтай, бие даан эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий өрхийн гишүүн – иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг хэлнэ. **/2 оноо/**

A. Тэтгэврийн нөхөн олговор

B. Нийгмийн хамгааллын тогтолцоо

C. Нийгмийн даатгалын сан

D. Нийгмийн халамж

E. Нөхцөлт мөнгөн тусламж

11. “Хүн бол бэлгэ тэмдгүүдийг бүтээдэг амьтан” гэж дараах эрдэмтдээс хэн нь тодорхойлсон бэ? **/1 оноо/**

A. К.Ясперс

B. Э.Тайлор

C. Ж.Мёрдок

D. Э.Дюркгейм

E. Э.Кассирер

12. Цэгийн оронд тохирох хариултыг олно уу? .....нь хүн өөрөө өөртэйгөө, гэр бүл хамт олонтой, бусад хүмүүстэй, нийгэмтэй харилцах харилцааг зохицуулж байдаг зарчим, шаардлагуудыг хэлнэ. **/1 оноо/**

A. Ёс суртахууны хэм хэмжээ

B. Ёс суртахуун

C. Ёс суртахууны ухамсар

D. Ёс суртахууны харилцаа

E. Ёс суртахууны үйлдэл

13. Цаг уурын өөрчлөлт, үр тариа, хий болон бусад нөөцийн хомсдол, хүн амын гэнэтийн өсөлт, бууралт зэрэг нь хүмүүсийг дасан зохицох явдалд хүчээр хүргэдэг. Энэ нь соёлын өөрчлөлтийн ямар эх үүсвэрт хамаарах вэ? **/1 оноо/**

A. Шинэ нээлт, бүтээл

B. Өөр хэм хэмжээ үнэт зүйлс, технологи бүхий бүлгүүдтэй холбоо тогтоох явдал

C. Байгаль орчны өөрчлөлт

D. Сэтгэлгээний өөрчлөлт

E. Хүн ам зүйн өөрчлөлт

14. Бүлэг, хамт олон, бие хүний үйлдэл нь нийтийн үнэлэмжид нийцэж байна уу, үгүй юу гэдгийг шүүн тунгаах үйл явцыг юу гэж нэрлэх вэ? **/2 оноо/**

A. Ёс суртахуун

B. Үнэлэмж

C. Үнэт зүйл

D. Үнэлгээ

E. Соёл

15. Шашны нийгэмд эзлэх байр суурь, үнэт зүйлсийг нь шалгуур болгон ангилсан ангилал аль нь вэ? **/1 оноо/**

A. Христийн, буддын, исламын шашин

B. Уламжлалт ба уламжлалт бус шашин

C. Овог, аймаг, улс үндэстний шашин

D. Австралийн болон далайн орнуудын шашин

E. Эх газрын болон уугуул Америкчуудын шашин

16. Бүтээгдэхүүний чанар, ажлын байрны нөхцөл, шударга өрсөлдөөнийг эрхэмлэх зэрэгт соёл ямар хэлбэрээр илрэн гарч байна вэ? **/1 оноо/**

A. Экологийн соёл

B. Эрх зүйн соёл

C. Ахуйн соёл

D. Эдийн засгийн соёл

E. Сэтгэлгээний соёл



17. Мэргэжлийн аль нэг бүлэгт хуваагдсан, нийтлэг зан төрхийн бэлгэ тэмдэг, үнэт зүйл, хэм хэмжээний үндсэн дээр бүрэлддэг дэд соёлыг юу гэх вэ? **/2 оноо/**

- A. Мэргэжлийн соёл  
B. Зонхилогч соёл  
C. Үндэсний соёл  
D. Шашны соёл  
E. Нийтийн соёл

18. Зарим үндэстэн хүч чадалгүй болсон хөгшин хүнийг хүйтэнд хөлдөж мөнхрөг гэж орхидог. Эрдэмтэд энэ зан үйлийг цаатан соёлын орчинд шинжлэн үзээд түүнийг хүнлэг ёс болохыг нь тогтоосон. Энэ нь соёлын ямар үзлийн илрэл вэ? **/1 оноо/**

- A. Дуализм  
B. Этноцентризм  
C. Универсал  
D. Плюрализм  
E. Релятивизм

19. Дараах бодомжуудын аль нь буруу томъёологдсон байна вэ? **/2 оноо/**

- A. Тэмдгийн тогтолцооны үндсэн үүрэг нь мэдээллийг дамжуулах буюу санаа бодлыг илэрхийлэх явдал  
B. Аливаа тэмдэг бүр ил юмуу далд утгыг илэрхийлдэг учир бэлгэ тэмдэг болдог.  
C. Аливаа тэмдэг бүр сайн сайхан зүйлийг агуулсан байдаг.  
D. Соёлыг бүтээнэ гэдэг нь хүн бодол санаагаа ямар нэг тэмдэгтэд төлөөлөл, бэлгэдэл болгон шингээж буй явдал  
E. Тэмдэг бол утгын төлөөлөл, тэмдгийн утга гэдэг нь тэмдгийн агуулж буй юмс, тэдгээрийн шинж харилцааны тухай мэдээлэл байдаг.

20. Ёс суртахууны зарчмуудыг зөв харгалзуулна уу? **/1 оноо/**

1	Хамтач үзэл	a	Хүний мөс чанарын илрэл
2	Хүмүүнлэг үзэл	b	Бусдын эрх ашгийг хүндлэх
3	Нинжин сэтгэл	c	Амьдралыг дээд үнэт зүйл гэж үзэх

- A. 1a 2b 3c  
B. 1b 2c 3a  
C. 1c 2a 3b  
D. 1a 2c 3b  
E. 1c 2b 3a

21. ДНБ /дотоодын нийт бүтээгдэхүүн/ гэж юуг хэлэх вэ? **/1 оноо/**

- A. Үндэсний нийт бүтээгдэхүүнээс үйлдвэрлэлийн явцад элэгдсэн капиталын элэгдлийн шимтгэлийг хасах  
B. Тухайн жилд нийт үйлдвэрлэлээс олсон орлогын нийлбэр  
C. Дотоод болон гадаад дахь хөрөнгө оруулалттай ААН-үүдийн нэг жилд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртөг  
D. Улсын хэмжээгээр нэг жилийн хугацаанд үйлдвэрлэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлчилгээний зах зээлийн үнийн дүн  
E. Үндэсний цэвэр бүтээгдэхүүнээс худалдаа үйлчилгээний шууд бус татварыг хасаад үлдэх хэсэг

22. Экстенсив хүчин зүйлсийг ашиглан эдийн засгийн өсөлтийг бий болгох аргыг тодорхойлно уу? **/1 оноо/**

- A. Түүхий эд материалыг хэмнэх  
B. Хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх  
C. Капитал болон ажилчдын тоог нэмэгдүүлэх  
D. Нэг га-гаас авах ургацын хэмжээг нэмэгдүүлэх  
E. Илүү их бүтээмжтэй машин техник нэвтрүүлэх

23. Чек гэж юу вэ? **/1 оноо/**

- A. Банкны хадгаламжид үндэслэн нэг тооцооны данснаас нөгөөд мөнгө шилжүүлэх банк хоорондын тооцооны тогтолцоо  
B. Тодорхой хугацаанд өрөө төлөх тухай зээлдэгчийн хүлээсэн үүргийг гэрчилсэн өр төлөх баталгаа  
C. Төв банкнаас гаргадаг мөнгөн тэмдэгт, банкны тасалбар  
D. Данснаас тодорхой хэмжээний мөнгө авах тухай өмчлөгчийн зөвшөөрөл  
E. Компьютерийн тусламжтайгаар хийгддэг банкны тооцооны тогтолцоо



24. Арилжааны банкны үйл ажиллагааны чиглэлд аль нь хамаарахгүй вэ? **/2 оноо/**  
 А. Зээлийн бүтээгдэхүүн гаргах  
 В. Мөнгөн хадгаламжийг хүлээж авах  
 С. Иргэдэд мөнгөн зээл олгох  
 D. Мөнгөн гүйлгээ болон тооцоо хийх  
 E. Мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах

25. Нөхөж бичнэ үү. Хөдөлмөрийн зах зээл дээр цалингийн түвшин өссөн гэвэл..... **/1 оноо/**  
 А. Хөдөлмөрийн нийлүүлэлт өснө.  
 В. Хөдөлмөрийн эрэлт өснө.  
 С. Хөдөлмөрийн нийлүүлэлт буурна.  
 D. Хөдөлмөрийн эрэлт буурна.  
 E. Хөдөлмөрийн эрэлт нийлүүлэлтийн тэнцвэр бий болно.

26. Суурь онтой харьцуулахад тухайн онд бүтээгдэхүүн үйлчилгээний үнэ хэдэн хувиар өссөнийг харуулдаг үзүүлэлтийг юу гэж нэрлэх вэ? **/1 оноо/**  
 А. Хэрэглээний бараа үйлчилгээний жин  
 В. Дефляци  
 С. Хэрэглээний сагс  
 D. Инфляци  
 E. Хэрэглээний үнийн индекс

27. Засгийн газрын хөтөлбөр боловсруулж түүнийг хэрэгжүүлэхэд зориулж төр зардлаа ихэсгэдэг. Энэ нь төрийн эдийн засгийн ямар бодлого вэ? **/1 оноо/**  
 А. Төрийн сангийн бодлого  
 В. Мөнгө, зээлийн бодлого  
 С. Гадаад худалдааны бодлого  
 D. Татварын бодлого  
 E. Хөрөнгө оруулалтын бодлого

28. Дараах өгөгдлүүдийг зөв харгалзуулна уу? **/2 оноо/**

1	Үйлдвэрлэлийн зардал	a	Үйлдвэрлэлийн тоо, хэмжээнээс шууд хамааран гардаг зардал
2	Хувьсах зардал	b	Үйлдвэрлэлийн тоо, хэмжээнээс үл хамааран гарч байдаг зардал
3	Тогтмол зардал	c	Үйлдвэрлэл явуулахад шаардлагатай нөөцийг худалдан авах, ашиглахтай холбогдон гарах мөнгөн төлбөр

- A. 1c 2b 3a      B. 1a 2c 3b      C. 1c 2a 3b      D. 1b 2a 3c      E. 1a 2b 3c

29. Нөхөж бичнэ үү. Валютын ханш гэдэг нь ..... хэлнэ. **/2 оноо/**  
 А. Төв банкнаас валютын арилжааны ханшийг өсгөхийг хэлнэ.  
 В. Гадаадын нэгж валютыг өөрийн валютаар худалдан авахыг хэлнэ.  
 С. Чөлөөтэй өсөж буурдаггүй валютын ханшийг хэлнэ.  
 D. Валютын тогтсон өртгийг төрөөс бууруулахыг хэлнэ.  
 E. Төв банк өөрийн нөөцөөс зардал гарган валютыг худалдан авахыг хэлнэ.

30. Сүүлийн үед манай улсын уул уурхайн компаниуд хөрөнгө оруулалт татах зорилгоор дэлхийн томоохон биржүүд дээр хувьцаагаа зарж эхэлсэн явдлыг хөрөнгө оруулалтын ямар хэлбэрээр тайлбарлаж болох вэ? **/2 оноо/**  
 А. Капиталын хөрөнгө оруулалт  
 В. Шууд хөрөнгө оруулалт  
 С. Шууд бус хөрөнгө оруулалт  
 D. Портфелийн хөрөнгө оруулалт  
 E. Татварын хөрөнгө оруулалт

31. Улс төрийн засаглалын үндсэн бүрдэлд аль нь үл хамаарах вэ? **/1 оноо/**  
 А. Засаглалын субъект  
 В. Засаглалын хэмжээ  
 С. Засаглалын объект  
 D. Засаглах арга  
 E. Засаглалын нөөц

32. Ардчилсан төрийн дотоод чиг үүргийг нэрлэхдээ хамааралгүй зүйл дурьдсан бол аль нь вэ? **/1 оноо/**  
 А. Эрх зүйн чиг үүрэг  
 В. Нийгмийн чиг үүрэг  
 С. Улс төрийн чиг үүрэг  
 D. Эдийн засгийн чиг үүрэг  
 E. Ёс зүйн чиг үүрэг



33. Дараах бодомжуудын аль нь оролцооны дэмжлэгт хамаарах вэ? **/1 оноо/**

- A. Аль нэг нэр дэвшигчийн төлөө саналаа өгөх  
 B. Цэргийн алба хаах  
 C. Хуулийг дагаж мөрдөх  
 D. Татвар төлөх  
 E. Төрийн бэлгэдлийг хүндэтгэх

34. Сонирхлын бүлэг нь улс төрийн үйл ажиллагааны дараах төрлүүдийн алийг нь голлон хэрэгжүүлдэг вэ? **/1 оноо/**

- A. Сонирхлыг хэрэгжүүлэх  
 B. Сонирхлыг дамжуулах  
 C. Сонирхлыг нэгтгэх  
 D. Сонирхлыг илэрхийлэх  
 E. Сонирхлыг боловсруулах

35. Сонгогчид зөвхөн нэр дэвшигч хүний төлөө саналаа гаргадаг бөгөөд өрсөлдөгчөөсөө илүү санал авсан нэр дэвшигч ялахыг сонгуулийн ямар тогтолцоо гэх вэ? **/2 оноо/**

- A. Хувь тэнцүүлэх тогтолцоо  
 B. Энгийн олонхийн саналаар сонгох  
 C. Харьцангуй олонхийн саналаар сонгох  
 D. Холимог тогтолцоо  
 E. Сонгодог тогтолцоо

36. Сонгодог ардчиллын үзэл санааны гол зарчмыг тоочихдоо илүүц зүйл дурьдсан бол аль нь вэ? **/1 оноо/**

- A. Олон түмэн өөрсдийн төр засгаа сонгож байгуулна.  
 B. Төрийн засаглалыг хэрэгжүүлэхэд ард түмэн нийтээрээ оролцох эрхтэй.  
 C. Нийгмийн доторх санаа бодлын илэрхийлэл болсон улс төрийн нам, бүлгүүдийн үүргийг чухалчлан үздэг.  
 D. Төр нь хүний нэр төр, эрх чөлөө, өмч хөрөнгийг хамгаалдаг.  
 E. Улс төрийн амьдралд иргэд тэгш эрхтэй оролцдог.

37. Дараах өгөгдлүүдийг зөв харгалзуулна уу? **/2 оноо/**

1	Либерал дэглэм	a	Ардчиллын үнэт зүйлсийг ард түмний дуу хоолой, шахалтаар хэрэгжүүлдэг.
2	Консерватив дэглэм	b	“Хуулиар хориглоогүй бүхнийг зөвшөөрнө” гэсэн зарчмыг мөрдлөг болгоно.
3	Охлократ дэглэм	c	Хүний салшгүй эрх болсон өмчлөх эрхийг хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журмын баталгаа гэж үзнэ

- A. 1a 2c 3b      B. 1b 2c 3a      C. 1b 2a 3c      D. 1c 2b 3a      E. 1c 2a 3b

38. “Нийгмийн доторх бүлэг хэсгүүд /элитүүд/ өөр хоорондоо өрсөлдөн олон түмний дэмжлэг авах замаар төрийн эрхийг эзлжлэн барих ба элитэд олон түмний санаа бодол, сонгууль зэргээс нөлөөлөх нь илүү” гэж үздэг ардчиллын онолыг нэрлэнэ үү? **/2 оноо/**

- A. Шууд ардчиллын онол  
 B. Сонгодог ардчиллын онол  
 C. Элитийн ардчиллын онол  
 D. Олон ургальч ардчиллын онол  
 E. Төлөөллийн ардчиллын онол

39. Дараах бодомжийн аль нь төрийн шинжид хамаарахгүй вэ? **/2 оноо/**

- A. Улсын хил нь нутаг дэвсгэрийн нэгэн адил халдашгүй дархан зүйл учир түүнийг зөрчихийг тухайн улсын бүрэн эрхт байдалд халдсан явдал гэж үздэг.  
 B. Орон зай буюу нутаг дэвсгэр нь улсын бүрэн эрхэд хадгалагдаж буй улсын хилээр хязгаарлагдсан байдаг.  
 C. Хүн ам нь төр улс үүсэх, орших үндэс гол субъект юм.  
 D. Нийтлэг эрх мэдлийг зөвхөн төр хэрэгжүүлдэг бөгөөд төрийн эрх мэдлийн эх сурвалж нь ард түмний хүсэл зориг байдаг.  
 E. Нийтлэг эрх ашиг гэдэг нь тухайн улс үндэстний амин чухал эрх ашгийг хөндсөн / тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хүний эрх, эрх чөлөө, удмын сан гэх мэт/ нийгмийн аль нэг гишүүн, бүлэг дангаараа шийдэж чадахааргүй асуудлууд юм.



40. Улс орноо батлан хамгаалах нь төрийн ямар үүрэгт хамаарах вэ? **/1 оноо/**  
 А. Гадаад үүрэг В. Дотоод үүрэг С. Үндсэн үүрэг  
 D. Хянан шалгах үүрэг E. Зохицуулах үүрэг
41. Үндсэн хуулийн цэцийн гишүүн Үндсэн хууль зөрчсөн тухай иргэний гомдлыг хүлээн аваад маргаан хянан шийдвэрлэх эсэх тухай асуудлыг хэний санаачилгаар шийдвэрлэдэг вэ? **/1 оноо/**  
 А. Олон нийтийн шаардсанаар В. Ерөнхийлөгчийн санаачилгаар  
 С. Ерөнхий сайдын санаачилгаар D. УИХ-ын санаачилгаар  
 E. Өөрсдийн санаачилгаар
42. Олон Улсын Улаан Загалмайн Хорооны үйл ажиллагаанд баримтлах суурь зарчмуудыг тоочихдоо илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? **/1 оноо/**  
 А. Сайн дурын үйлчилгээ үзүүлэх В. Хүмүүнлэг байх С. Алагчлалгүй байх  
 D. Нэг талын ашиг сонирхолд үйлчлэх E. Түгээмэл байх
43. Биет эд хөрөнгийг юу гэж ангилдаг вэ? **/1 оноо/**  
 А. Нийтийн ба хувийн В. Эдийн ба оюуны үнэт зүйл С. Хөдлөх ба үл хөдлөх  
 D. Төрийн ба олон нийтийн E. Иргэний ба дундын
44. Нөхөж бичнэ үү. .... гэдэг нь захиргааны байгууллагын буруугаас иргэдийн болон ААН-ийн эрх зөрчигдөж, зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр хандаж буй харилцааны хэлбэр мөн. **/2 оноо/**  
 А. Санал В. Гомдол С. Гэрээ D. Хэлцэл E. Мэдэгдэл
45. Хүсэл зоригийн дагуу эрх, эд юмсыг хууль ёсоор мэдэлдээ байлгаж, арчлан хамгаалж байх нь ямар эрх вэ? **/1 оноо/**  
 А. Захиран зарцуулах эрх В. Ашиглах эрх С. Эзэмших эрх  
 D. Зохицуулах эрх E. Шийдвэрлэх эрх
46. Хууль зүйн үүднээс заавал биелүүлэх шинжтэй дэг журмыг заасан эрх зүйн баримт бичгүүдийг дурьдахдаа илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? **/2 оноо/**  
 А. Олон улсын шүүх арбитрын шийдвэр  
 B. Олон улсын байгууллагын заавал биелүүлэх шийдвэр  
 C. Олон улсын эрх зүйн нэг талын баримт бичиг  
 D. Олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн ёс зүйн хэм хэмжээ  
 E. Заншил /олон улсын харилцааны нэгэнтээ хэвшиж заншсан үзэл санаа/
47. Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээнд тавигдах шаардлагыг тоочихдоо илүүц зүйл дурьдсан бол аль нь вэ? **/2 оноо/**  
 А. Шат дамжлагатай байх В. Мэдлэгт суурилсан байх  
 C. Чадварт суурилсан байх D. Шударга ёсонд суурилсан байх  
 E. Хариуцлагад суурилсан байх
48. Өмгөөллийн байгууллага ямар чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллага вэ? **/1 оноо/**  
 А. Биелүүлэх В. Шалгах С. Гэм бурууг тогтоох  
 D. Хяналт тавих E. Өмгөөлөх
49. Олон нийтэд ил тод байх ёстой хэмээн үздэг төрийн байгууллагын мэдээллүүдийг тоочихдоо илүүц зүйл дурьдсан бол аль нь вэ? **/1 оноо/**  
 А. Төрийн байгууллагуудад хадгалагдаж буй албан ёсны бичиг баримтууд  
 B. Төрийн байгууллагын үйлчилгээ, үйл ажиллагааны тухай мэдээлэл  
 C. Төрийн байгууллагад хадгалагдаж буй олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн, эсхүл тэдний сэтгэл санааг зовоож буй мэдээлэл  
 D. Төрийн албан хаагчийн хувийн хэрэг  
 E. Төрийн албан хаагч, ажилтнуудын ажил үүрэгтэй холбоотой мэдээлэл



50. Хуулийн этгээдийн үндсэн шинжид аль нь хамааралгүй вэ? **/2 оноо/**  
 А. Өөрийн үйл ажиллагаагаараа эрх олж, үүрэг бий болгох чадвартай байх  
 В. Тусгайлсан эд хөрөнгөтэй байх  
 С. Заавал нэхэмжлэгч байх  
 D. Үйл ажиллагаанаасаа үүсэн гарах үүргийг эд хөрөнгөөрөө хариуцдаг байх  
 E. Шүүх, арбитраж өөрийн нэрийн өмнөөс оролцдог байх

51. Дараах бодомжуудын аль нь олон улсын улс төрийн харилцаанд хамаарах вэ? **/1 оноо/**  
 А. Улс орнуудын хоорондын хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалт  
 В. Улс орнууд бие биетэйгээ дипломат харилцаа тогтоох  
 С. Олон улсын техник, технологийн салбар дахь хамтын ажиллагаа  
 D. Олон улсын аялал жуулчлалын салбар дахь хамтын ажиллагаа  
 E. Үндэсний эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах

52. Дараах өгөгдлүүдийн аль нь олон улсын харилцааны хоёр туйлт системийн гол онцлог шинжийг илэрхийлж байна вэ? **/1 оноо/**  
 А. Өөрсдийн хүчийг нэмэгдүүлэхийг байнга эрмэлздэг, нөгөө эвслийн гишүүнийг өөртөө татах, өөрийн гишүүдийг алдахгүйн төлөө тэмцдэг  
 В. Өөрийн нөлөөнд буй улс орнуудын хоорондын зөрчилдөөнийг зохицуулах, эвсэлд нэгдсэн орнуудын салан тусгаарлах болон бие даах оролдлогыг таслан зогсоодог.  
 С. Ноёрхогч шинжтэй болж буй аливаа улс, эвслийг эсэргүүцдэг.  
 D. Нөгөө хоёр талтай аль алинтай нь сайн харилцаатай байх, зөрчил үүсэхээс болгоомжилдог.  
 E. Аль нэг талтай нь дайтсан ч тогтолцоог /системийг/ тогтворгүйжүүлэх хэрэггүй гэж үздэг.

53. Олон улсын эрх зүй ба ёс зүйн хариуцлагыг зохицуулах үүрэг, үйлчлэх хүрээ, үйлчлэх хугацаагаар нь ангилдаг. Тэгвэл дараах ангиллуудыг тоочихдоо илүүц зүйл дурьдсан бол аль нь вэ? **/1 оноо/**

- А. Хугацаатай ба хугацаагүй  
 В. Түгээмэл  
 С. Бүс нутгийн  
 D. Орон нутгийн  
 E. Нийтлэг

54. Олон улсын харилцааны хандлагуудыг зөв харгалзуулна уу. **/2 оноо/**

1	Даяаршил	a	Олон улсын харилцаа тэгш байдалд үндэслэн дэлхийн улс гүрнүүд хамтран ажиллах үйл явц
2	Бүс нутаг, салбар бүс нутгийн интеграцлал	b	Нийгмийн дотоодод, цаашилбал, улс гүрнүүдийн хүрээнд хамтын ажиллагаа, хоорондын хамаарал улам бүр өргөн хүрээтэй, олон талтай, эргэлт буцалтгүй болж буй үйл явц
3	Хамтын ажиллагаа	c	Эдийн засгийн хөгжилд тулгуурласан хүчний төвүүд бий болж бүс нутгийн хүрээнд хамтрах үйл явц

- A. 1c 2b 3a      B. 1a 2c 3b      C. 1b 2a 3c      D. 1b 2c 3a      E. 1c 2a 3b

55. Олон улсын харилцаан дахь Монгол улсын хувьд стратегийн ач холбогдол бүхий гүрнүүдийн Монгол дахь эдийн засгийн болон бусад сонирхлыг тэнцвэржүүлэхэд чиглэсэн байх шаардлагыг юу гэж нэрлэдэг вэ? **/1 оноо/**

- А. Олон тулгуурт бодлого      В. Идэвхтэй бодлого      С. Тэнцвэртэй бодлого  
 D. Нээлттэй бодлого      E. Үндэсний эрх ашигт нийцсэн бодлого

56. Хүн төрөлхтний түүхэнд олон улсын харилцаа хэдийд үүссэн бэ? **/1 оноо/**

- А. Дундад зууны үеэс      В. Төр улс анх үүссэн үеэс  
 С. Сэргэн мандалтын үеэс      D. Дэлхийн 1-р дайны үеэс  
 E. Дэлхийн 2-р дайны үеэс



**ХОЁРДУГААР ХЭСЭГ****Санамж:**

1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож, хариуг бөглөөрэй.
2. Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноо

2.1 Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу?

**/6 оноо/**

a	Хувь хүн	1	Тухайн хүний нийгэмд эзэлж буй байр суурь, эрх үүргийн нэгдэл
b	Бие хүн	2	Хоёр ба түүнээс дээш хоорондоо нийцэхгүй үүргийн эсрэг, тэсрэг шаардлагыг зайлшгүй биелүүлэх нөхцөл
c	Нийгмийн үүрэг	3	Хүмүүсийн олж авч буй байр суурь буюу статусаас хүсэн хүлээж буй зүйл
d	Нийгмийн статус	4	Тухайн хүний статуст тохирох үүргийн цогц
e	Үүргийн тогтолцоо	5	Нийгмийн харилцааны эзэн, нийгмийн шинжийг эзэмшсэн иргэншсэн хүн
f	Үүргийн мөргөлдөөн	6	Дахин давтагдашгүй өвөрмөц шинж бүхий хүн

2.2 Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу?

**/6 оноо/**

a	Эрэлт	1	Барааны борлуулалт буурах
b	Сөрөг эрэлт	2	Борлуулалт нь улирлаас хамаарч өсөж буурах
c	Далд эрэлт	3	Эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэг
d	Буурч байгаа эрэлт	4	Худалдан авах чадвараар баталгаажсан хэрэгцээ
e	Жигд бус эрэлт	5	Тухайн бараанд хэрэглэгчид тааламжгүй хандах
f	Зохисгүй эрэлт	6	Зах зээлд байгаа бараагаар хэрэгцээгээ хангах боломжгүй хүсэл

2.4 Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу?

**/6 оноо/**

a	Төрийн алба	1	Захиргааны зөрчил гаргасан этгээдэд хүлээлгэх хариуцлагын арга хэмжээ
b	Төрийн албан хаагч	2	Төр нийтийн ашиг сонирхол, хувийн ашиг сонирхол хоорондоо зөрчилдөх
c	Төрийн захиргаа	3	Төрийн зорилт, чиг үүргийг хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа
d	Төрийн захиргааны байгууллагууд	4	Төрийн албан тушаалыг эрхэлж, бүрэн эрхээ хэрэгжүүлж, төрөөс цалин хөлс авч буй хүмүүсийн бүлэг
e	Захиргааны шийтгэл	5	Хуулийг хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүргээ төрийн зүгээс өөрийн байгууллага, албан хаагчдаараа дамжуулан хэрэгжүүлэх үйл явц
f	Ашиг сонирхлын зөрчил	6	Монгол улсын хуулийг хэрэгжүүлж, гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд төрийн үйлчилгээг иргэдэд үзүүлэх үүрэгтэй байгууллагууд

2.5 Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу?

**/6 оноо/**

a	Хүний эрх, эрх чөлөө	1	Тухайн орны иргэд хүсэл зорилгоо илэрхийлэх нэг арга зам бол төр засагт өөрсдийгөө төлөөлөх албан тушаалтныг сонгох явдал
b	Иргэдийн улс төрийн оролцоо	2	Нэгээс дээш нам улс төрийн амьдралд идэвхтэй оролцож тодорхой үүрэг гүйцэтгэх
c	Тэгш эрхийн зарчим	3	Хүн бүр хуулийг сахин, түүнийг зөрчвөл хариуцлага хүлээх
d	Чөлөөт шударга сонгууль	4	Хувь хүний нийгмийн харилцаанд оролцох боломж, хэм хэмжээг илэрхийлсэн ойлголт
e	Олон намын тогтолцоо	5	Иргэд төрийн хэрэгт оролцох нь тэдний эрх төдийгүй иргэнийхээ хувьд хүлээж байгаа ёс суртахууны үүрэг
f	Хуульд захирагдах ёс	6	Ямар ч иргэнийг ижил боломжтой байлгаж, арьс өнгө, шашин шүтлэг, үндэс угсаа, хүйс, үзэл бодлоор ялгаварлахгүй байх

